

Ажиллах хүчний судалгаа 2013

Үндэсний статистикийн хороо

Үүссэн огноо: October 27, 2014

Вэб хуудас: <http://web.nso.mn/nadamn/index.php>

Ерөнхий мэдээлэл

Тодорхойлолт

ДУГААР

DDI-MN-NSO-LFS-2013

Хувилбар

ХУВИЛБАРЫН ТАЙЛБАР

Хувилбар 1.0

ҮҮССЭН ОГНОО

2014-10-08

Ерөнхий мэдээлэл

ТОВЧ

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн заалтыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг баяжуулж, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан дүн шинжилгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, хөдөлмөрийн зах зээлийг зөв төлөвшүүлэн хөгжүүлэхэд бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, бизнес эрхлэгчид, шинжлэн судлаачид, төр захиргааны ажилтан хэн бүхэнд гарын авлага, тогтмол мэдээллийн эх сурвалжийг бий болгоход судалгааны зорилго оршино.

МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ

Sample survey data [ssd]

СУДАЛГААНЫ НЭГЖ

Өрх

Хүрээ

ТЭМДЭГЛЭЛҮҮД

Ажиллах хүчний судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодит тоон мэдээллийг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд тооцож, тодорхойлно. Иймд судалгааг байршлын хувьд Монгол Улсыг бүхэлд нь хамруулан өргөн цар хүрээнд явуулж, улсын хэмжээнд 5 бүс нутгийн (Төв, Баруун, Зүүн, Хангай, Улаанбаатар) нийт 12816 өрхийг хамрууллаа. Энэ нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг бодитой тооцоход хангалттай төлөөлөл болно гэж үзлээ. Жилийн хугацаанд хамрагдсан нийт өрхийн дөрөвний нэгийг тухайн улирлын судалгаанд хамруулсан болно. Судалгааны мэдээллийг сар бүр цуглуулан, үр дүнг улирлаар нэгтгэж, боловсруулалт хийсэн. Судалгаа нь өрхөд суурилан явагдаж байгаа тул цэргийн хуаран, дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, сүм хийд болон нийтийн байранд түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүн амыг хамруулаагүй болно.

Ажиглалтын хүрээ

ГАЗАР ЗҮЙН ХҮРЭЭ

Судалгаанд 21 аймаг тус бүрийг нэг бүлэг, Улаанбаатар хотын 9 дүүргийг 8 бүлэгт (хамгийн цөөн өрхтэй 2 дүүргийг нэг бүлэгт хамруулсан) хувааж нийт 29 бүлэг болгон хамруулсан.

ХҮРЭЭ

Өрх, өрхийн гишүүд

Гүйцэтгэгч болон түнш

ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА

Нэр	Харьяалал
Үндэсний статистикийн хороо	УИХ

Мета мэдээлэллийн боловсруулалт**БОЛОВСРУУЛСАН**

Нэр	Товчилсон үг	Харьяалал	Үүрэг
Үндэсний статистикийн хороо	ҮСХ	УИХ	Баримтжуулалт хийсэн.

МЕТА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛСАН ОГНОО

2014-10-08

БИЧИГ БАРИМТЫН ХУВИЛБАР

Хувилбар 1.0

БИЧИГ БАРИМТЫН ДУГААР

DDI-MN-NSO-LFS-2013

Түүвэрлэлт

Түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийн нэгж нь өрх бөгөөд нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг “өрх” гэж ойлгоно. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг оруулаагүй болно.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үндэслэн судалгааны түүврийн үндсэн нэгжийг тогтоосон. Судалгаанд 21 аймаг тус бүрийг нэг бүлэг, Улаанбаатар хотын 9 дүүргийг 8 бүлэгт (хамгийн цөөн өрхтэй 2 дүүргийг нэг бүлэгт хамруулсан) хувааж нийт 29 бүлэг болгон хамруулсан. Судалгааны ТАШН нь Улаанбаатар хотын хувьд дүүргийн хорооны хэсэг, харин аймгийн хувьд багууд болно. Энэ түүвэр судалгаанд Улаанбаатар хотоос түүврийн анхан шатны 304, аймгаас 764, нийт 1068 нэгжийг, тухайн нэгж тус бүрээс 12 өрхийг сонгон хамруулснаар судалгааны үр дүнг аймаг, нийслэл, дүүргийн түвшинд тооцох боломжтой болж байна.

Түүврийн хэлбэлзэл

Түүвэр судалгаа хийгдэж байгаатай уялдан дараах 2 төрлийн алдаа гарч байдаг.

Үүнд:

- 1) Түүврийн алдаа;
- 2) Түүвэрлэлтийн бус алдаа;

Түүвэрлэлтийн бус алдаа нь тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах үйл явцын үед гардаг. Энэхүү алдаанд судалгааны бэлтгэл үе шат, мэдээлэл цуглуулах үед хийсэн судлаач, мэдээлэгчийн санамсаргүй болон санаатай хийсэн алдаа, боловсруулалтын шатанд гарсан алдааг хамруулан авч үздэг. Түүвэрлэлтийн бус алдаа нь гарсаар байдаг бөгөөд судалгааг явуулах бүхий л үе шатанд багасгах арга хэмжээг авдаг. Нөгөөтэйгүүр түүвэрлэлтийн бус алдааг статистикийн аргаар тооцоолох боломж хомс байдаг. Харин түүврийн алдааг статистикийн аргаар тооцоолдог.

Нийт олонлогоос түүвэрлэн авсан ажиглалт дээр тулгуурлан үр дүнг тооцдог улбаалан түүврийн алдаа гардаг. Түүврийн алдаа тухайн судалгааг хийхэд ашигласан түүврийн төрөл болон түүврийн хэмжээнээс хамаарна. Энэхүү алдааг боломжит түвшинд байлгах үүднээс түүврийн загвар болон түүврийн хэмжээг сонгосон.

Улсын хэмжээнд тодорхойлогдсон түүврийн анхан шатны нэгжээс судалгаа авч үр дүнг тооцсонтой холбоотойгоор судалгааны үр дүн бодит утгаас ямар хэмжээний хэлбэлзэлтэй байгааг түүвэрлэлтийн алдаа илэрхийлнэ. Түүврийн загвар болон түүврийн хэмжээнд тулгуурлан алдааг тооцсон бөгөөд зарим нэг үзүүлэлтийн алдааны хязгаар өндөр байх нь түүврийн загварыг сонгох үе шатанд харагдаж байсан.

Судалгааны түүвэрлэлтийн алдааг дараах үзүүлэлтийн тусламжтайгаар тооцоолсон бөгөөд түүврийн алдааг илэрхийлэх гол үзүүлэлт нь вариацийн коэффициент болно.

Ерөнхийн олонлогийн үзүүлэлтийн тооцооны утга

Стандарт алдаа

Вариацийн коэффициент

95 хувийн итгэмжлэгдэх интервал

Тооцоо хийхэд ашиглагдсан ажиглалтын тоо

Түүвэрлэлтийн алдааг судалгааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд улсын түвшин, хот, хөдөө, хүйс, бүс нутаг, аймгийн хэмжээнд гэсэн ангиллаар тооцсон.

Түүврийн жин

Судалгааны түүврийн жин доорх томьёоны дагуу тодорхойлогдоно.

1. Дэд түүвэрлэлт тус бүр дэх түүврийн анхан шатны жин тооцох томьёо
2. Дэд түүвэрлэлтийг нэгтгэсэн түүврийн анхан шатны нэгжийн жин тооцох томьёо
3. $t - p$ улирлын жин тооцох томьёо

Судалгааны үр дүнгийн нарийвчлал, төлөөлөх чадварыг гаргах нь тооцооны зайлшгүй хэсэг юм.

Дундаж, харьцаа гэх мэт үзүүлэлтийн тооцооны утгын далайц, хэмжих нэгж нь өөр өөр байдгаас хамааран тухайн судлагдаж байгаа үзүүлэлтийн талаар хийгдсэн янз бүрийн судалгааны үр дүнгийн стандарт алдаануудыг шууд харьцуулах боломж олгодог. Түүврийн хэмжээ болон түүврийн арга нь түүврийн алдаа хэр зэрэг их, бага байхыг

тодорхойлох бөгөөд зарим үзүүлэлтийн хувьд түүврийн алдаа өндөр байх боломжтой бөгөөд эдгээр тоог ашиглахдаа анхааралтай байх хэрэгтэй.

Асуулгууд

Ерөнхий мэдээлэл

Судалгааны асуулга нь 8 бүлэг 142 асуултаас бүрдэж байна. Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан, эдийн засгийн тухайн үеийн болон байнгын идэвхийн тодорхойлолт, тооцох аргачлалын дагуу судалгааны асуулгад дараах мэдээллийг багтаасан болно. Үүнд:

1. Өрхийн гишүүдийн байдал (өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох, хүйс, төрсөн он, сар, өдөр, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, гэрлэлтийн байдал, шилжих хөдөлгөөнд оролцсон эсэх);
2. Боловсрол ба сургалт (сургуульд суралцсан, суралцаж байгаа эсэх, сургуулиас завсардсан шалтгаан, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг, мэргэжил олгох болон ур чадвар олгох сургалтанд хамрагдсан эсэх);
3. Сүүлийн 7 хоног буюу тухайн үеийн идэвх (эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа, түүнд зарцуулсан цаг, эдийн засгийн идэвхтэй, идэвхгүй байдал, үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн статус, ажил мэргэжлийн ангилал, үндсэн ажлынхаа цалин хөлсийг ямар хугацааны давтамжтай авдаг, авч буй цалин, хөлс, орлого);
4. Нэмэлт ажил хийх боломж (нэмэлт ажил хийх боломжтой эсэх, нэмэлт ажил хийх боломжгүй байсан шалтгаан, нэмэлт ажил хайсан хэлбэр);
5. Ажилгүй иргэн (ажил хийхэд бэлэн байсан эсэх, эдийн засгийн идэвхгүй байсан шалтгаан, ажил хайсан хугацаа, ямар төрлийн/ажил мэргэжлийн ажил хийх хүсэлтэй байгаа, авахыг хүсэж буй цалингийн хэмжээ (өдрийн, сарын), хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй эсэх, сүүлийн 30 хоногт ажил хайсан эсэх, ажил хайсан хэлбэр, ажил хайгаагүй шалтгаан, ажлгүй байсан хугацаа);
6. Эдийн засгийн байнгын идэвх (сүүлийн 12 сарын буюу эдийн засгийн байнгын идэвх, үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтийн статус, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, ажилгүй байсан хугацаа, ажил хайсан хэлбэр, сүүлийн 12 сард үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлтээс авсан дундаж цалин хөлс, орлого) ;
7. Өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт (өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн байдал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хамгийн сүүлийн ажлыг гүйцэтгэсэн хугацаа, хамгийн сүүлийн ажлаа хийхээ больсон шалтгаан, ажилгүй байх хугацаан дахь амьжиргааны эх үүсвэр);
8. Цалин хөлсгүй ажил, үйлчилгээ (өрхийн гишүүд цалин хөлсгүй ажил, үйлчилгээнд оролцсон эсэх, түүнд зарцуулсан цаг);

Мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулалтын огноо

Эхлэх	Дуусах	Цикл
2013-01-01	2013-12-31	N/A

Мэдээлэл цуглуулалтын бодлого

Face-to-face [f2f]

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

Судалгааны ажилтан болох судлаач нь сонгогдсон өрхөд очиж 15 ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан. Сонгогдсон өрхөө судалгаанд бүрэн хамруулахын тулд судалгаа авах үеэр өрх эзгүй байх тохиолдолд тухайн өрхөд эргэж 2-3 удаа очиж, судалгааны хамралтыг нэмэгдүүлдэг. Судалгаанд өрхийг бүрэн хамруулах, мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор судалгааны багийн ахлагч, аймаг, нийслэлийн статистикийн газар хэлтсээс хяналт тавьж мөн ҮСХ-ны дарга, дэд даргаар ахлуулсан “Цогц үнэлгээний баг” болон судалгааг хариуцсан газар, нэгжийн мэргэжилтнүүдээс бүрдсэн хяналтын баг АХС-ны ажлын явцыг хянаж шалган, гарсан ололт, дутагдлыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

Мэдээлэл боловсруулалт

Мэдээлэл засалт

Судалгааны мэдээлэл боловсруулах ажлыг 2 үе шаттайгаар явуулсан. Судалгааны асуулга боловсруулах болон мэдээллийг шивэх программыг бэлтгэх, компьютерт шивэгдсэн мэдээллийн бүрдэлтийг шалган хүлээн авах, хянах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ҮСХ-нд, харин мэдээлэл цуглуулалтыг өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт шивж оруулах, ҮСХ-нд дамжуулах ажлыг нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн ажиллах хүчний судалгаа хариуцсан багийн ажилтнууд хийж гүйцэтгэсэн.

АХС-ны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлахад тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CSPro багц программыг, бэлэн болсон мэдээллийн үр дүнг нэгтгэж боловсруулах, холбогдох хүснэгтүүдийг тооцож гаргахад SPSS программыг тус тус ашиглан, улмаар статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянан, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнг боловсруулсан.

Мэдээллийн үнэлэлт

No content available

Файлын тайлбар

variable_list

АХС 2013_mon

Агуулга

Тохиолдолууд 44678

Хувьсагч 220

Бүтэц Төрөл:
Түлхүүрүүд: ()

Хувилбар

Гүйцэтгэгч

Missing Data

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн матрица	Асуулт
V1	PSU	2. ТАШН-ийн дугаар	contin	numeric	
V2	SSU	3. ТХШН-ийн дугаар	discrete	numeric	
V3	AD	Аймаг/ нийслэл	discrete	numeric	
V4	SD	05. Сум/ дүүрэг	contin	numeric	
V5	BD	06. Баг/ хороо	contin	numeric	
V6	KHESEG	07. Хэсэг	discrete	numeric	
V7	LOCATION	Суурьшил	discrete	numeric	
V8	QUARTER	11. Улирал	discrete	numeric	
V9	VISITS	16. Судалгаа авахаар очсон удаа	discrete	numeric	
V10	SURCODE	17. Судалгаанд хамрагдалтын дүн	discrete	numeric	
V11	REASON	18. Сонгогдсон өрх судалгаанд хамрагдаагүй шалтгаан	discrete	numeric	
V12	HNSIZE	Өрхийн ам бүлийн тоо	discrete	numeric	
V13	AGEOVER5	5 ба түүнээс дээш насны хүний тоо	discrete	numeric	
V14	AWAY1	Бүгд дүн	discrete	numeric	
V15	AWAY2	Суралцаж байгаа дүн	discrete	numeric	
V16	AWAY3	Ажиллаж байгаа дүн	discrete	numeric	
V17	AWAY4	Бусад дүн	discrete	numeric	
V18	AWAY5	6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа 15,+ насны хүний тоо -Бүгд	discrete	numeric	
V19	AWAY6	6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур суралцаж байгаа 15,+ насны хүний тоо - Суралцаж буй	discrete	numeric	
V20	AWAY7	6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур ажиллаж байгаа 15,+ насны хүний тоо - Ажиллаж буй	discrete	numeric	
V21	AWAY8	6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа 15,+ насны хүний тоо - Бусад	discrete	numeric	
V22	SYR	Судалгаа эхэлсэн он	discrete	numeric	
V23	SMTH	Сар	discrete	numeric	
V24	SDAY	Өдөр	contin	numeric	
V25	SHR	Цаг	contin	numeric	
V26	SMIN	Минут	contin	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн үзэг	Асуулт
V27	FYR	Судалгаа дууссан он	discrete	numeric	
V28	FMTH	Сар	discrete	numeric	
V29	FDAY	Өдөр	contin	numeric	
V30	FHR	Цаг	contin	numeric	
V31	FMIN	Минут	contin	numeric	
V32	REASON_DESC	18.03 Шалтгааны тайлбар	discrete	character	
V33	reaso001	18.03 Шалтгааны тайлбар	discrete	character	
V34	P2	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V35	I2	I.2. Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай вэ?	discrete	numeric	
V36	I3	Хүйс	discrete	numeric	
V37	I5	I.5. Нас (бүтэн жилээр)	contin	numeric	
V38	I6	I.6. Та хөгжлийн ямар нэгэн бэрхшээлтэй юу?	discrete	numeric	
V39	I7	I.7. Таны хөгжлийн бэрхшээл төрөлхийнх үү, эсвэл олдмол уу?	discrete	numeric	
V40	I8	I.8. Та ямар шалтгаанаар хөгжлийн олдмол бэрхшээлтэй болсон бэ?	discrete	numeric	
V41	I9A	I.9а. Та харах эрхтний хөгжлийн бэрхшээлтэй юу?	discrete	numeric	
V42	I9B	I.9б. Та сонсох эрхтний хөгжлийн бэрхшээлтэй юу?	discrete	numeric	
V43	I9C	I.9в. Та хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй юу?	discrete	numeric	
V44	I9D	I.9г. Та тулах эрхтний хөгжлийн бэрхшээлтэй юу?	discrete	numeric	
V45	I9E	I.9д. Та сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй юу?	discrete	numeric	
V46	I9F	I.9е. Та бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй юу?	discrete	numeric	
V47	P3	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V48	I10	I.10. Гэрлэлтийн байдал	discrete	numeric	
V49	I11	I.11. Сүүлийн 5 жилд 6 сараас дээш хугацаагаар одоо амьдарч байгаа газраас өөр газар амьдарч байсан уу?	discrete	numeric	
V50	I12	I.12. Одоо амьдарч байгаа газартаа хэдэн сарын өмнө ирсэн бэ?	contin	numeric	
V51	I13	I.13. Та өмнө нь хаана амьдарч байсан бэ?	discrete	numeric	
V52	I14	I.14. Та өмнө нь хотод амьдарч байсан уу, хөдөө амьдарч байсан уу?	discrete	numeric	
V53	I15	I.15. Таны шилжих болсон үндсэн шалтгаан юу байсан бэ?	discrete	numeric	
V54	P4	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V55	II16	II.16. Та аль нэг шатны сургуульд сурдаг эсвэл суралцаж байсан уу?	discrete	numeric	
V56	II17	II.17. Та ямар шалтгаанаар сургуульд огт суралцаагүй болон сургуулиас завсардсан вэ?	discrete	numeric	
V57	II18	II.18. Та эзэмшсэн боловсролын түвшнээ хэлнэ үү?	discrete	numeric	
V58	II19	II.19. Та бичиг үсэг мэддэг үү?(Та энгийн өгүүлбэр уншиж, бичиж чадах уу?)	discrete	numeric	
V59	II20	II.20. Ажил мэргэжилийн код	discrete	numeric	
V60	II21	II.21. Та сүүлийн 3 жилд шинээр мэргэжил болон ур чадвар олгох сургалтанд хамрагдсан уу?	discrete	numeric	
V61	II22A	II.22а. Та ямар төрлийн(чиглэлийн) сургалт, дамжаанд хамрагдсан вэ?	discrete	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн үзэгс	Асуулт
V62	II22B	II.22б. Та ямар төрлийн(чиглэлийн) сургалт, дамжаанд хамрагдсан вэ?	discrete	numeric	
V63	II22C	II.22в. Та ямар төрлийн(чиглэлийн) сургалт, дамжаанд хамрагдсан вэ?	discrete	numeric	
V64	P5	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V65	III23	III.23. Цалин хөлстэй ажилд	contin	numeric	
V66	III24	III.24. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, мал аж ахуй эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчийн ажилд (	contin	numeric	
V67	III25	III.25. МАА, газар тариалан	contin	numeric	
V68	III26	III.26. Ан агнуур, ойн аж ахуй болон мод бэлтгэх	contin	numeric	
V69	III27	III.27. Ашигт малтмал олборлох	contin	numeric	
V70	III28	III.28. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх	contin	numeric	
V71	III29	III.29. Нэхмэл, сүлжмэл, гутал, хувцас хийх, оёх, засварлах	contin	numeric	
V72	III30	III.30. Барилга барих, их засварын үйл ажиллагаа	contin	numeric	
V73	III31	III.31. Худалдаа, үйлчилгээ	contin	numeric	
V74	III32	III.32. Эд зүйлс, ахуйн жижиг засвар үйлчилгээ үзүүлэх	contin	numeric	
V75	III33	III.33. Тээврийн үйлчилгээ	contin	numeric	
V76	III34	III.34. Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ	contin	numeric	
V77	III35	III.35. Аялал жуулчлал	contin	numeric	
V78	III36	III.36. Хувиараа хичээл заах, сургалт явуулах, хүүхэд асрах гэх мэт	contin	numeric	
V79	III37	III.37. Бусад	contin	numeric	
V80	III38	III.38. Нийт цаг 38=(23+24)	contin	numeric	
V81	P6	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V82	III39	III.39. Эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа хийсэн цаг (38-р баганад байгаа цагийг хуулж бичнэ.)	contin	numeric	
V83	III40	III.40. Та сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй боловч ер нь тогтмол ажилтай юу?	discrete	numeric	
V84	III41	III.41. Та сүүлийн 7 хоногт ямар мэргэжлийн ажил эрхэлсэн бэ?	discrete	numeric	
V85	III42	III.42. Энэ ажлыг 7 хоногт дунджаар хэдэн цаг хийдэг вэ?	contin	numeric	
V86	III43	III.43. Та энэ ажлыг ямар давтамжтайгаар хийж байна вэ?	discrete	numeric	
V87	III44	III.44. Та энэ ажлаа хэр удаан хийж байна вэ?	discrete	numeric	
V88	III45	III.45. Таны одоо эрхэлж буй ажил эзэмшсэн мэргэжилд тань тохирдог уу?	discrete	numeric	
V89	III46	III.46. Та хөдөлмөр эрхлэлтийн статусаа хэлнэ үү	discrete	numeric	
V90	III47	III.47. Таны ажлын байр хаана байдаг вэ?	discrete	numeric	
V91	III48	III.48. Таны эрхэлдэг ажлын (байгууллагын) үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?	discrete	numeric	
V92	P7	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V93	III49	III.49. Таны ажилладаг ААН, байгууллагын хариуцлагын хэлбэр юу вэ?	discrete	numeric	
V94	III50	III.50. Та хувийн ямар аж ахуйн нэгжид ажилладаг вэ?	discrete	numeric	
V95	III51	III.51. Та ямар үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжид ажилладаг вэ?	discrete	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн формат	Асуулт
V96	III52	III.52. Та үйл ажиллагаандаа тайлан тэнцэл гаргадаг уу?	discrete	numeric	
V97	III53	III.53. Та үйл ажиллагаандаа зориулж банк болон санхүүгийн байгууллагаас зээл авдаг уу?	discrete	numeric	
V98	III54	III.54. Та ямар төрлийн татвар төлдөг вэ?	discrete	numeric	
V99	III55	III.55. Та зах зээлд бараагаа зарах/ үзүүлэх эсвэл солилцоо хийдэг үү?	discrete	numeric	
V100	III56	III.56. Таны ажилладаг ажлын байр албан ёсны бүртгэлтэй юу?	discrete	numeric	
V101	III57A	III.57A. Та татварын байгууллагад бүртгэлтэй юу?	discrete	numeric	
V102	III57B	III.57B. Та нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй юу?	discrete	numeric	
V103	III57C	III.57C. Та бусад төрлийн байгууллагад бүртгэлтэй юу?	discrete	numeric	
V104	III58	III.58. Таныг оролцуулаад танай аж ахуйн нэгж, байгууллагад хичнээн хүн тогтмол ажилладаг вэ?	discrete	numeric	
V105	III59	III.59. Цалин хөлстэй ажиллагчид нь хэд байна вэ?	discrete	numeric	
V106	III60	III.60. Та ажилдаа ер нь хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?	discrete	numeric	
V107	P8	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V108	III61	III.61. Та үндсэн ажлынхаа цалин хөлсийг ямар хугацааны давтамжтайгаар авдаг вэ?	discrete	numeric	
V109	III62A	III.62а. Сүүлийн долоо хоногт эрхэлсэн үндсэн ажлаасаа хэдэн төгрөгийн цалин хөлс бэлэн мөнгөөр авсан бэ? (мөн.төг)	contin	numeric	
V110	III62B	III.62б. Сүүлийн долоо хоногт эрхэлсэн үндсэн ажлаасаа хэдэн төгрөгийн цалин хөлс бэлэн бус хэлбэрээр авсан бэ? (мөн.тө	contin	numeric	
V111	III63	III.63. Та цалин авсанаа ямар баримтаар баталгаажуулдаг вэ?	discrete	numeric	
V112	III64	III.64. Та ямар төрлийн гэрээтэй ажилладаг вэ?	discrete	numeric	
V113	III65A	III.65а. Танай байгууллага, ажил олгогч дараах тэтгэмж, тэтгэлэг, хөнгөлөлтийг олгодог/төлдөг уу? : НДШ	discrete	numeric	
V114	III65B	III.65б. Жирэмсэн болон хүүхэд асарсны тэтгэмж	discrete	numeric	
V115	III65C	III.65в. Шагнал урамшуулал, нэмэгдэл цалин хөлс	discrete	numeric	
V116	III65D	III.65г. Хүнд, хортой нөхцөл, тусгай албаны нэмэгдэл	discrete	numeric	
V117	III65E	III.65д. Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	discrete	numeric	
V118	III65F	III.65е. Тэтгэвэрт гарахтай холбогдуулан олгох тусламж	discrete	numeric	
V119	III65G	III.65ё. Ээлжийн амралттай холбогдуулан олгох тусламж	discrete	numeric	
V120	III65H	III.65з. Мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт	discrete	numeric	
V121	III65I	III.65ж. Ажлаас гэнэт халсны тэтгэмж	discrete	numeric	
V122	P09	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V123	III66	III.66. Сүүлийн 7 хоногт ямар нэгэн давхар ажил хийсэн үү?	discrete	numeric	
V124	III67	III.67. Сүүлийн долоо хоногт давхар ажил эрхлээгүй боловч тогтмол хийх давхар ажилтай юу?	discrete	numeric	
V125	III68	III.68. Та сүүлийн долоо хоногт ямар мэргэжлийн давхар ажил эрхэлсэн бэ?	discrete	numeric	
V126	III69	III.69. Давхар ажлаа 7 хоногт хэдэн цаг хийдэг вэ?	contin	numeric	
V127	III70	III.70. Давхар ажлыг хэдий хугацаагаар эрхэлж байна вэ?	discrete	numeric	
V128	III71	III.71. Та давхар эрхэлдэг ажлынхаа хөдөлмөр эрхлэлтийн статусаа хэлнэ үү?	discrete	numeric	
V129	III72	III.72. Таны давхар эрхэлдэг ажлын байр хаана байдаг вэ?	discrete	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн матрица	Асуулт
V130	III73	III.73. Таны давхар эрхэлдэг ажлын (байгууллагын) үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?	discrete	numeric	
V131	III74	III.74. Таны давхар ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр юу вэ?	discrete	numeric	
V132	P10	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V133	III75	III.75. Та ямар хувийн аж ахуйн нэгж, байгууллагад давхар ажилладаг вэ?	discrete	numeric	
V134	III76	III.76. Та ямар үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад давхар ажилладаг вэ?	discrete	numeric	
V135	III77	III.77. Та давхар үйл ажиллагаандаа тайлан тэнцэл гаргадаг уу?	discrete	numeric	
V136	III78	III.78. Та давхар үйл ажиллагаандаа зориулж банк болон санхүүгийн байгууллагаас зээл авдаг уу?	discrete	numeric	
V137	III79	III.79. Та давхар үйл ажиллагаандаа ямар төрлийн татвар төлдөг вэ?	discrete	numeric	
V138	III80	III.80. Та давхар үйл ажиллагаагаараа зах зээлд бараагаа зарах/ үйлчилгээ үзүүлэх эсвэл солилцоо хийдэг үү?	discrete	numeric	
V139	III81	III.81. Таны давхар ажилладаг ажлын байр албан ёсны бүртгэлтэй юу?	discrete	numeric	
V140	III82A	III.82а. Та ямар байгууллагад бүртгэлтэй вэ? Татварын байгууллага	discrete	numeric	
V141	III82B	III.82б. Нийгмийн даатгалын байгууллага	discrete	numeric	
V142	III82C	III.82в. Бусад	discrete	numeric	
V143	III83	III.83. Таныг оролцуулаад таны давхар ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагад хичнээн хүн тогтмол ажилладаг вэ?	discrete	numeric	
V144	III84	III.84. Цалин хөлстэй ажиллагчид нь хэд байна вэ?	discrete	numeric	
V145	III85A	III.85а. Та сүүлийн 7 хоногт эрхэлсэн давхар ажлаасаа хэдэн төгрөгийн цалин бэлэн мөнгөөр авсан бэ? (мян.төг)	contin	numeric	
V146	III85B	III.85б. Та сүүлийн 7 хоногт эрхэлсэн давхар ажлаасаа хэдэн төгрөгийн цалин бэлэн бус хэлбэрээр авсан бэ? (мян.таг)	contin	numeric	
V147	P11	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V148	IV86	IV.86. Та сүүлийн 7 хоногт нэмэлт ажил хийх боломжтой байсан уу?	discrete	numeric	
V149	IV87	IV.87. Та сүүлийн 7 хоногт яагаад нэмэлт ажил хийгээгүй вэ?	discrete	numeric	
V150	IV88	IV.88. Та ямар хугацааны турш нэмэлт ажил хийх бололцоотой байсан бэ?	discrete	numeric	
V151	IV89	IV.89. Та сүүлийн 30 хоногт нэмэлт ажил яаж хайсан ба?	discrete	numeric	
V152	P12	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V153	V90	V.90. Та сүүлийн 7 хоногт ажил эрхлэхэд бэлэн байсан уу?	discrete	numeric	
V154	V91	V.91 Ирэх 14 хоногт ажил хийхэд бэлэн эсэх	discrete	numeric	
V155	V92	V.92. Таны ажилгүй байсан шалтгаан юу вэ?	discrete	numeric	
V156	V93	V.93. Та сүүлийн 30 хоногт ажил хайсан уу?	discrete	numeric	
V157	V94A	V.94а. Та сүүлийн 30 хоногт хэрхэн ажил хайсан бэ?	discrete	numeric	
V158	V94B	V.94б. Та сүүлийн 30 хоногт хэрхэн ажил хайсан бэ?	discrete	numeric	
V159	V94C	V.94в. Та сүүлийн 30 хоногт хэрхэн ажил хайсан бэ?	discrete	numeric	
V160	V95	V.95. Та сүүлийн 30 хоногт яагаад ажил хайгаагүй вэ?	discrete	numeric	
V161	V96	V.96. Та ямар хугацааны турш ажил хийх боломжтой байсан бэ?	discrete	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн матрица	Асуулт
V162	V97	V.97. Та ямар төрлийн ажил хийх бодолтой байна вэ?	discrete	numeric	
V163	V98A	V.98a. Энэ ажлыг хийхэд наад зах нь өдрийн хэдэн төгрөгний цалин хөлс авна гэж бодож байна вэ? : Өдрийн цалин (мян.төг)	contin	numeric	
V164	V98B	V.98b. Энэ ажлыг хийхэд наад зах нь цагийн хэдэн төгрөгний цалин хөлс авна гэж бодож байна вэ? : Цагийн цалин (мян.төг)	contin	numeric	
V165	V99	V.99. Та хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн үү?	discrete	numeric	
V166	P13	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V167	VI100	VI.100. Сүүлийн 12 сарын ихэнх хугацаанд (6 ба түүнээс дээш сар) ажил хийсэн эсвэл хийхэд бэлэн байсан уу?	discrete	numeric	
V168	VI101	VI.101. Сүүлийн 12 сард ажил хийгээгүй болон хийхэд бэлэн биш байсан (эдийн засгийн идэвхгүй) шалтгаан тань юу вэ?	discrete	numeric	
V169	VI102	VI.102. Сүүлийн 12 сард ажил хийсэн хугацаа тань ажил хийхэд бэлэн байсан хугацаанаас их байсан уу?	discrete	numeric	
V170	VI103	VI.103. Сүүлийн 12 сард яаж ажил хайсан бэ?	discrete	numeric	
V171	VI104	VI.104. Та ямар хугацаанд ажил хийхэд бэлэн байсан болон ажил хайсан бэ?	discrete	numeric	
V172	VI105	VI.105. Сүүлийн 12 сард ямар мэргэжлийн үндсэн ажил эрхэлсэн бэ?	discrete	numeric	
V173	VI106	VI.106. Сүүлийн 12 сард эрхэлсэн ажлын тань (байгууллагын) үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?	discrete	numeric	
V174	VI107	VI.107. Та энэ ажлыг хэр удаан эрхэлж байна вэ?	discrete	numeric	
V175	VI108	VI.108. Сүүлийн 12 сард эрхэлсэн үндсэн ажлынхаа хөдөлмөр эрхлэлтийн статусыг хэлнэ үү?	discrete	numeric	
V176	VI109	VI.109. Таны ажилладаг ажлын байр албан ёсны бүртгэлтэй юу?	discrete	numeric	
V177	VI110	VI.110. Таны ажлын байр хаана байдаг вэ?	discrete	numeric	
V178	P14	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V179	VI111A	VI.111a. Сүүлийн 12 сарын туршид эрхэлсэн үндсэн ажлын сарын дундаж орлого хэд вэ? (мян.төг)	contin	numeric	
V180	VI111B	VI.111b. Сүүлийн 12 сарын туршид эрхэлсэн үндсэн ажлын өдрийн дундаж орлого хэд вэ? (мян.төг)	contin	numeric	
V181	VI112	VI.112. Сүүлийн 12 сарын туршид та давхар ажил хийсэн үү?	discrete	numeric	
V182	VI113	VI.113. Сүүлийн 12 сард ямар мэргэжлийн давхар ажил эрхэлсэн бэ?	discrete	numeric	
V183	VI114	VI.114. Сүүлийн 12 сард эрхэлсэн давхар ажлын (байгууллагын) үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?	discrete	numeric	
V184	VI115	VI.115. Сүүлийн 12 сард эрхэлсэн давхар ажлынхаа хөдөлмөр эрхлэлтийн статусыг хэлнэ үү?	discrete	numeric	
V185	VI116	VI.116. Таны давхар эрхэлдэг ажлын байр тань албан ёсны бүртгэлтэй юу?	discrete	numeric	
V186	VI117	VI.117. Таны давхар эрхэлдэг ажлын байр хаана байдаг вэ?	discrete	numeric	
V187	VI118A	VI.118a. Сүүлийн 12 сард эрхэлсэн нийт ажлын сарын дундаж орлого хэд вэ? (мян.төг)	contin	numeric	
V188	VI118B	VI.118b. Сүүлийн 12 сард эрхэлсэн нийт ажлын өдрийн дундаж орлого хэд вэ? (мян.төг)	contin	numeric	
V189	VI119A	VI.119a. Хэрэв та цалин хөлстэй ажиллагч бол сүүлийн 12 сард хэдэн удаа ажлаа солисон бэ?	discrete	numeric	
V190	VI119B	VI.119b. Хэрэв цалин хөлстэй ажиллагч бол сүүлийн 3 жилд хэдэн удаа ажлаа солисон бэ?	discrete	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн үзэгс	Асуулт
V191	P15	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V192	VII120	VII.120. Та урьд өмнө хөдөлмөр эрхэлж байсан уу?	discrete	numeric	
V193	VII121	VII.121. Та хамгийн сүүлд ямар мэргэжлийн үндсэн ажил эрхэлсэн бэ?	discrete	numeric	
V194	VII122	VII.122. Таны хамгийн сүүлд эрхэлж байсан ажлын (байгууллагын) үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?	discrete	numeric	
V195	VII123	VII.123. Та энэ ажлыг хэр удаан хийсэн бэ?	discrete	numeric	
V196	VII124	VII.124. Та хамгийн сүүлд эрхэлсэн ажлынхаа хөдөлмөр эрхлэлтийн статусаа хэлнэ үү?	discrete	numeric	
V197	VII125	VII.125. Та сүүлчийн ажлаа хийхээ болиод хэр удаж байна вэ?	discrete	numeric	
V198	VII126	VII.126. Таны ажиллаж байсан аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэр юу вэ?	discrete	numeric	
V199	VII127	VII.127. Таны сүүлчийн ажлаа хийхээ больсон шалтгаан юу байсан вэ?	discrete	numeric	
V200	VII128A	VII.128A. Та ажилгүй байх хугацаандаа ямар орлого/тусламжаар амьдарч байна вэ?	discrete	numeric	
V201	VII128B	VII.128B. Та ажилгүй байх хугацаандаа ямар орлого/тусламжаар амьдарч байна вэ?	discrete	numeric	
V202	VII128C	VII.128C. Та ажилгүй байх хугацаандаа ямар орлого/тусламжаар амьдарч байна вэ?	discrete	numeric	
V203	P16	A. Хувийн дугаар	discrete	numeric	
V204	VIII129	VIII.129. Та сүүлийн 7 хоногт хоол цай бэлтгэх, аяга таваг цэвэрлэх үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд хэдэн цаг з	contin	numeric	
V205	VIII130	VIII.130. Та сүүлийн 7 хоногт хоол гэр хашаа цэвэрлэх үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд хэдэн цаг зарцуулсан вэ?	contin	numeric	
V206	VIII131	VIII.131. Та сүүлийн 7 хоногт хувцас угаах, индүүдэх үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд хэдэн цаг зарцуулсан вэ?	contin	numeric	
V207	VIII132	VIII.132. Та сүүлийн 7 хоногт сууц, эд хогшил сэргээн засах үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд хэдэн цаг зарцуулса	contin	numeric	
V208	VIII133	VIII.133. Та сүүлийн 7 хоногт гэрийнхээ хэрэгцээт зүйлийг худалдан авах, дэлгүүр явах үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн	contin	numeric	
V209	VIII134	VIII.134. Та сүүлийн 7 хоногт хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд	contin	numeric	
V210	VIII135	VIII.135. Та сүүлийн 7 хоногт ус авах үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд хэдэн цаг зарцуулсан вэ?	contin	numeric	
V211	VIII136	VIII.136. Та сүүлийн 7 хоногт түлээ, түлш бэлтгэх үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд хэдэн цаг зарцуулсан вэ?	contin	numeric	
V212	VIII137	VIII.137. Та сүүлийн 7 хоногт өндөр настан, өвчтөн асрах үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд хэдэн цаг зарцуулсан	contin	numeric	
V213	VIII138	VIII.138. Та сүүлийн 7 хоногт хүүхэд асрах үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд хэдэн цаг зарцуулсан вэ?	contin	numeric	
V214	VIII139	VIII.139. Та сүүлийн 7 хоногт ашиг олох зорилгоор бус мал, гэрийн тэжээвэр амьтан тэжээх, цэцэг ногоо тарих, арччлах үй	contin	numeric	
V215	VIII140	VIII.140. Та сүүлийн 7 хоногт нүүх, ачаалах, гэр барих үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн ажилд хэдэн цаг зарцуулсан вэ	contin	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V216	VIII141	VIII.141. Та сүүлийн 7 хоногт олон нийтийн болон сайн дурын ажилд цалин хөлсгүйгээр оролцох үйл ажиллагааг эрхэлсэн бол	contin	numeric	
V217	VIII142	VIII.142. Та сүүлийн 7 хоногт цалин хөлсгүй үйл ажиллагаанд нийт хэдэн цаг зарцуулсан вэ?	contin	numeric	
V218	STRATUM	Аймаг/ дүүрэг	discrete	numeric	
V219	weightQ		contin	numeric	
V220	weightY		contin	numeric	